


## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

### Я.Ишбалдан

Он сар өдөр, төрсөн газар	1916, Дундговь аймгийн Цагаандэлгэр сум
Үндсэн сүм хийд	Баруун цоргын хийд
Б.Ринченгийн сүм, хийдийн нэр	Баруун цоор хийд
Ярилцлаганд дурдагдсан бусад сүм хийдүүд	Тулгын жас, Хонгор толгойн жас, Баян-Уулын жас, Залаагийн жас, Дарь эхийн жас, Баруун Чойжин, Зүүн Чойжин, Ловонгийн жас



Дундговь аймаг, Цагаандэлгэр сум, Баруун Чойрын хийдийн

**- За эхлээд таниас хэдэн зүйлийг асууя. Та хэдэн онд лам болсон бэ?**

За найман нас өнгөрч есөн настай лам болсон. Одоо 91 настай.

**- Хэдэн онд төрсөн бэ?**

1916 онд төрсөн. Гэрээрээ хоёр жил ном үзсэн. Тэгээд Чойр дацанд суусан.

**- Чойр дацанд хэдэн жил суув аа?**

10 наснаас эхлэн таран тартал суусан.

**- Танай дацан хэдэн ламтай байсан?**

Манай дацан мянгаад шавьтай байсан.

**- Үгүй ээ, танай Чойр дацан? Нийлээд бүгд хэдэн ламтай байсан бэ?**

1500-аад лам байсан байх.

**- Танай Чойр ямар ихчойтой байсан бэ? Ванчин, гүнчин гээд байдаг ш дээ?**

Аа за Дамдин чой.

**- Номын нэр хэлчихлээ. Гүнчин ихчойтой байсан уу?**

Тийм, гүнчин.

**- Та Чойрын ямар зиндаад сууж байсан бэ?**

Банчин зиндаа дуусгаж байсан.

**- Чойрын дуганы гол сахиус нь юу байв?**

Хандам сахиус.

**- Сүмбүм үү?**

Үгүй ээ, хандам гээд л бид нар сурчихсан юм. Зарим хүмүүс одоо сүмбүм гэдэг юм билээ.

**- Гол цогчин дуган чойрын дацангийнхаа хаана нь байсан бэ?**

Яг чанх урд нь байсан.

**- Чойрын дацангийн зүүн талд ямар дацангууд байсан бэ?**

Мамба, ламиран дацангууд байсан.

**- Зүүн хойно нь ямар дацан байсан бэ?**

Чойрын дацангийн зүүн хойно нь дуган байгаагүй. Хойно нь л байсан.

**- Тэр модон хашааны ард уу?**

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Чойрын хийдэд модон хашаа байгаагүй дээ. Ёга баруун талд нь, яг хойно нь дүйнхор байсан. 7 дацантай байсан юм шүү.

**- Дуган бүр жастай юу?**

Тэгэлгүй дээ.

**- Цам гарч майдар эргэнэ биз дээ?**

Цам гарна. Майдар эргэнэ. Улаан сахиусны цам сарын хорин есөнд гарна.

**- Сар болгон уу, эсвэл аль сард?**

Намрын сүүл сарын хорин есөнд цам гарч, сор зална.

**- Цам нь хаанаа гарч байсан бэ, цогчин дуганыхаа өмнө үү?**

Юу гэнэ ээ, за байз санахгүй байна. Сахиус залаад л...

**- Зоч лам нар байсан уу?**

Байсан.

**- Зоч нар тусгай дугантай байсан уу?**

Үгүй ээ, тийм дуган байгаагүй. Гадуур яваад л хүний хойдох авч лүйжин тавьдаг байсан.

**- Хандам сахиусаа хэзээ тахиж байсан?**

9 сарын арван хэдэнд л тахидаг байсан.

**- Одоо энэ Баруун Чойрын хийдийн туурин дээр байгаа шинэ суварга аль дуганы туурин дээр байна?**

Чойрын дуганы туурин дээр байна.

**- Хуучин суварганууд нь хаана хаана байсан?**

Хүрээнийхээ дөрвөн өнцөгт байсан юм.

**- Их том доогуур нь бараг хүн гараад явчихаар тийм суварга байсан юм уу?**

Өө тийм, тийм. Их өндөр том суварга байсан.

**- Таны багад хийдийн хамба лам хэн гэдэг хүн байсан бэ?**

Аа, Долзод Бямбаа гэдэг хүн байсан байх.

**- Чойжин буудаг байсан уу?**

Аа үзэж чадаагүй, тийм яриа байдаг л байсан.

**- Хутагт хувилгаад байв уу?**

Том том мундаг лам нар байсан. Минжүүр Дондов гэж их том лам байлаа. Их цагаан лам гэж их том лам байлаа.

**- Хийдийн ойролцоо энгийн айлууд борчууд байсан уу?**

Байхгүй ээ, дан лам нар байсан.

**- Хятадууд байсан уу?**

Үгүй ээ, байхгүй.

**- Хийдийн ойр орчим ямар овоо тахилга байсан бэ?**

Ноён овоо, Их цагаан уул, Бага цагаан уулыг тахидаг байсан.

**- Баруун Чойрын хийдээс одоо бага жижиг хөдөөгийн жасууддаа гарч хурал хурдаг байсан уу?**

Өө тэгэлгүй дээ. Отог отгийн жасуудад лам нар гарч хурал хурна.

**- Энэ Цагаандэлгэр сумын нутагт Цэгээний жас гэж байгаа юм. Зүүн цэгээний нуур гэж байна. Тэнд тийм Цэгээний жас гэж байсан уу?**

Үгүй ээ, тэр Цэгээний жас биш. Баян-Уулын жас гэж байсан юм.

**- Та энэ хавьд байсан жасуудын тухай нэрсийг нь хэлээд зарим нэг мэдэх зүйлээ бидэнд ярьж өгнө үү? Манайх энэ Жалгын жас гэж ярьдаг тэр хөдөөгийн жасуудын тухай?**

За манай энэ хавьд Тулгын жас, Хонгор толгойн жас, Баян-Уулын жас, Залаагийн жас, Дарь эхийн жас, Баруун Чойжин, Зүүн Чойжин гээд жасууд байсан. Бас Ловонгийн жас. За Тулгын жас гэдэг чинь Зүлэгтэйн жас юм. За Хонгор толгойн жас чинь Ламын жас байгаа юм. За тэр Хутаг уулын хажууд Дарь эхийн жас гэж байсан юм.

**- Халдайн жас гэж сонссон уу, та?**

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хадат аа? Аа Халдай. Үгүй ер сонсоогүй юм байна. Ловонгийн жас энэ чинь Цэгээнээс баруун хойно байдаг.

### - Тэнд олон дуган байсан уу?

Үгүй ээ, цөөхөн байсан. Нэг гэр дуган, жижиг шүтээний модон дуган байсан, лам нар ч тогтмол байхгүй. Баян уулын жас чинь манай отгийн жас. Миний гол нутаг. Би олон удаа очиж байсан юм. Гурван дугантай байсан. Дарь эхийн жасад Зүүн Чойр манай хоёроос лам нар очиж хурал хийнэ. Тулгын жас, Хонгор толгойн жасад Баруун Чойроос лам нар очиж хурал хийнэ.

### - Баруун Чойжин хоёр чинь нэг дор байсан юм уу, хоёр тусдаа байсан юм уу?

Энэ хоёр чинь хоёр тусдаа. Баруун Чойжин сумын төвөөс зүүн урд, Залаагийн уулын баруун хойно байсан юм. Ламшын дуган гэж нэг дугантай, өөр дугангүй. Зүүн Чойжингийн тухай мэдэхгүй. Сонссоноос цаашгүй. Очиж үзээгүй.

### - Зүүн Чойжин чинь Гучтын жас мөн болов уу?

Үгүй ээ, мэдэхгүй. Очоогүй болохоор мэдэхгүй. Энэ жасууд чинь тогтсон лам нар байхгүй, ихэнхэд нь. Тэгэхээр тогтмол хурал үгүй. Зөвхөн тахилч лам нар байна. Дандаа мөнх зултай. Тэгээд л тэр дуганч лам нар зул хүжээ өргөөд, бурхан тахилын тоосыг арчаад л байж байна. Ийм л байсан юм.

### - Хүрээ хийдээс тэгээд хэзээ голдуу энэ жасуудад гарч лам нар хурал хурах вэ?

Ихэнхдээ голдуу зун л хурал хурна. Дацангуудын лам нар отог отгийн жасад хуваарлигдаад л 45 хоног хайлан хурна.

### - Ловонгийн хурал чинь аль зүгт байгаа билээ, сумаас?

Баруун тийш 20 км-т байгаа.

### - Тэр жас хэдэн дугантай байсан бол?

Аа мэдэхгүй, би очиж байгаагүй. Лав л Арван хангал хурж байсан юм гэнэ лээ.

### - Жасууд хэдэн онд хаагдсан бэ?

Аа Чойр хаагдахад л.

### - Чойр хэдэн онд хаагдсан юм бэ?

За байз, мянга есөн зуун хорин хэдэн онд хаагдсан байх.

### - Тийм эрт хаагдсан юм уу?

Тэгэлгүй яахав.

### - Одоо та энэ сумын төвд байгаа Шинэ дуганы талаар хэдэн онд байгуулагдсан юм, хэн гэдэг ямар лам нартай байсан юм ямар хүч хөрөнгөөр босгосон энэ тухай ярьж өгөхгүй юу?

Ард түмний хөрөнгө санал санаачилгаар л боссон юм. Анх 40-өөд ламтай хурал эхэлсэн. Бүгд өвгөчүүд. Урд шавь лам явсан хүмүүс. Хамгийн залуу нь л би байсан байх.

### - Тэр урд байсан Ламын хуралд хурдаг байсан Хонгор толгойн тэнд хувилгаан лам чинь нэр нь хэн билээ?

Дашжамц гэж лам байсан юм.

### - Энэ Шинэ хийдийн хашаан доторх хоёр суварга ямар учиртай суварга вэ?

Дүвээ багш гэж байсан юм. Тэр багшийн хойтоход зориулж энэ суваргыг босгосон юм. Тэр олон хүрдийг чинь дандаа л энэ улсууд хүмүүс бүтээцгээсэн юм. өөрсдөө л саналаараа Мөнгө хандивыг нь өгөөд л бүтээлгэсэн юм.

### - За за өвгөөн. Одоо боллоо. Гялайлаа танд.

Ярилцсан: М.Жужа, Т.Кристина, О.Энхбаяр